




2024 11-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 3-Р УЛИРАЛД 5%-ИАР ӨСЛӨӨ.

- 2024 оны 3 дугаар улиралд худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт сайн байж, татварын орлого нэмэгдсэн нь эдийн засгийн идэвхжилд эергээр нөлөөлж, нийт өсөлтийн 4.6%-ийг бүрдүүлсэн байна. Уул уурхайн салбарын нийт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө өмнөх жилийн өндөр суурийн нөлөөгөөр буурч, бодит ДНБ-ийн өсөлтийн 1.4%-ийг бүрдүүлжээ. Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, ХАА-н салбар 25%-иар агшсанаар, эдийн засгийн өсөлтөд 3.5%-ийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.
- Цаашлаад төрийн болон өрхийн хэрэглээ эдийн засгийн өсөлтийг голлон тайлбарлаж байгаа бөгөөд өрхийн хэрэглээ нь импортыг нэмэгдүүлж, манай улсын цэвэр экспорт алдагдалтай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

2025 ОНЫ ТӨСӨВТ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАВЬСАН ХОРИГИЙГ УИХ-ААС ХҮЛЭЭЖ АВЛАА.

- Жил бүрийн 11 сард дараа жилийн улсын төсвийг УИХ баталдаг бөгөөд 2025 оны төсвийн төсөлд төрийн зардал 35.8 их наяд төгрөг хүрэхээр УИХ-д өргөн баригдаж батлагдсан ч алдагдалгүй төсөв батлах шаардлагатай гэж Ерөнхийлөгч үзсэн. Ийнхүү 2025 оны төсвийн төсөлд бүхэлд хориг тавьснаар УИХ хүлээж авлаа.
- Он гарснаас хойш төсвийн зардал 10 сарын байдлаар 22.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 32.2%-иар өссөн бол нийт төсвийн зардлын 31.4%-ийг бараа, үйлчилгээний зардал, 19.2%-ийг нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал, 21.1%-ийг хөрөнгийн зардал бүрдүүлж байна.
- Харин эдийн засгийн идэвхжилийг дагаад ААН, иргэдийн орлого нэмэгдсэн нь татварын орлого нэмэгдэхэд голлон нөлөөлж өмнөх оны мөн үеэс 26.3%-иар өсөж 22.2 их наяд төгрөгт хүрлээ. Улмаар улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 23.8 их наяд хүрч, төсвийн тэнцэл 1.5 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцэл ашигтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 26.1%-иар буурсан байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ 3.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ ГАРСАН Ч ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕЭС 26%-ИАР БУУРСАН БАЙНА

- 2024 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 14%-иар өсөж 22,7 тэрбум ам.доллар хүрлээ. Үүнд экспорт 6%-иар буюу 733 сая ам.доллараар өсөж, импорт 27%-аар буюу 2,020 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Улмаар гадаад худалдааны тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарсан ч өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум ам.доллараар буюу 26%-иар буурчээ.
- Нүүрсний экспортын биет хэмжээ 10 сарын байдлаар 68.5 сая тоннд хүрснээр нийт экспортын орлогыг дэмжиж 7.3 тэрбум ам.долларын орлого олсон байна. Харин зэсийн экспортоос 2.6 тэрбум ам.долларын орлого олсон бол алтны экспортоос 793 сая ам.долларын орлого олсон байна.
- Нийт экспорт 733 сая ам.доллараар өсөхөд 56% нь зэсийн экспортын өсөлтөөс шалтгаалсан бол 250 сая ам.доллар буюу 34.1% нь нүүрсний экспортоос шалтгаалсан байна. Нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.5%-иар өссөн ч хилийн үнэ 10 сард тонн тутамд 97\$ болж буурсан байна.

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ 4.9 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР БАЙНА.

- Монгол банкнаас 11 сарын 25-нд гадаад валютын нөөцийн мэдээллийг олон нийтэд хүргэсэн бөгөөд үүнд гадаад валютын нөөц 4.9 тэрбум ам.доллар хүрсэн нь 5.1 сарын импортыг хангахуйц байгаа талаар мэдээлсэн юм. Гадаад валютын албан нөөц өндөр байх нь ханшид үзүүлэх дарамтыг бууруулдаг бөгөөд төгрөгт итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.
- Он гарснаас хойш төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсаар байгаа бөгөөд үүнд үйлчилгээний импортын гарах урсгал урсгал дансны алдагдлаар дамжин нөлөөлж байна. Тухайлбал 10 сарын байдлаар төлбөрийн тэнцлийн урсгал данс 1,285 сая ам.долларын алдагдалтай гарсан бол төлбөрийн тэнцлийн алдагдал 250 сая ам.долларт хүрчээ.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q3	2024Q2	2023Q3	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	22,828	14,407	21,751	5.0%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M10	2024M9	2023M10	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	12,264	11,783	11,348	8.1%
Зэс	сая ам доллар	2,617	2,264	2,204	18.7%
Нүүрс	сая ам доллар	7,307	6,653	7,048	3.7%
Нийт импорт	сая ам доллар	9,580	8,608	7,560	26.7%
Хэрэглээ	сая ам доллар	-2,891	-2,548	-2,185	32.3%
Түүхий эд	сая ам доллар	-788	-713	-699	12.7%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-4,107	-3,711	-3,173	29.4%
Шатахуун	сая ам доллар	-1,780	-1,623	-1,487	19.7%
Тэнцэл	сая ам доллар	3,627	3,174	4,917	-26.2%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9,534	9,259	7,941	20.1%
Нүүрс	\$/тонн	153.2	148.7	150.7	1.7%
Газрын тос	\$/баррель	75.3	73.1	88.9	-15.3%
Алт	\$/трой унц	2,689	2,569	1,914	40.5%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,523	2,937	2,062	-26.1%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	23,867	22,759	18,962	25.9%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-22,344	-19,822	-16,900	32.2%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M10	2024M9	2023M10	
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	42,092	41,803	33,692	24.9%
ХҮИ (C2020)	индекс	147.6	146.8	137.9	7.0%
Бодлогын хүү	%	10.00%	10.00%	13.00%	-23.1%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,405	3,381	3,448	-1.2%
Төгрөгийн хадгаламж	%	12.10%	11.50%	11.90%	1.7%
Валютын хадгаламж	%	4.90%	3.90%	3.60%	36.1%
Төгрөгийн зээл	%	17.00%	17.10%	16.70%	1.8%
Валютын зээл	%	9.10%	10.90%	10.90%	-16.5%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,701	4,663	3,977	18.20%

БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ий өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН


■ Ажилгүйдлийн түвшин

— Дундаж нэрлэсэн цалин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ



Эх сурвалж: Монголбанк


ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк


2024

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

С. Цацрал

Цахим хаяг: tsatsral.sa@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.